


БАТЛАВ.  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Ж. БАТЖАРГАЛ



БАТЛАВ.  
ЗААМАР СУМЫН ИТХ-ЫН ДАРГА  
Ш.ГАЛТБАДРАХ

№02

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР  
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ  
ТУХАЙ ГЭРЭЭ**

Энэхүү гэрээг нэг талаас Төв аймгийн Заамар сумын Засаг дарга Бямбадорж овогтой Самбуу (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч **УЛЗ ГОЛ ХХК**-ны захирал ажилтай **А.Бүрэнтогтох** (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож **2019 оны 03 дугаар сарын 29-ны өдөр** Төв аймгийн Заамар суманд байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.3. Ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй энэхүү гэрээг тухайн сумын Засаг дарга байгуулна.

1.4 Энэхүү гэрээг ..... оны ..... сарын ..... -ны өдөр олгогдсон **MV004411** дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулна.

1.5 Орон нутагт хийх бүтээн байгуулалтын ажлын өртөг болон мөнгөн хандив тусламжийн хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 25.3-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно.



## **Хоёр. Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.3. энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

2.1.7. Аймаг, сумын Засаг даргын удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж буй ажлын хэсэг тухайн объектод саадгүй нэвтрэн орох

### **Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;



**3.1.4. Сумын харьяат иргэнийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ... иргэнийг, түр 15 иргэнийг байнгийн ажлын байраар ханган ажиллах;**

**3.1.5. өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;**

**3.1.6. хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн сумын иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;**

**3.1.7. бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;**

**3.1.7.1 малчин иргэдээс хуваарийн дагуу 10 үхэр, 15 хонь,... ямаа, .... адуу, 5000 литр сүү цагаан идээ, 500кг төмс, хүнсний ногоо худалдан авах**

**3.1.7.2 Орон нутгийн жижиглэн худалдаа эрхлэгчид уурхайн тоснонд очиж худалдаа хийхийг дэмжиж ажиллана.**

**3.1.7.3 Сумын оёдлын цехээр 100 хос ажлын хувцас, ..... ш комбинзон, 100 хос гутлыг тус тус захиалан хийлгэх**

**3.1.8. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;**

**3.1.9. гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.**

**3.1.10 Сум орон нутгийн хөгжилд зориулж дэд бүтэц, нийгмийн салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр “Заамар нутгийн хөгжлийг дэмжих” сан ТББ-ын үйл ажиллагааг дэмжин ажиллах**

**3.1.11 Аймаг, сумын Засаг даргын удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж буй ажлын хэсгийг тухайн объектод саадгүй нэвтрүүлэх**

**3.1.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх**

**3.1.13 Биологийн нөхөн сэргээлтийн талбайн 2-оос доошгүй га-д тэжээлийн ургамал тарьж хүлээлгэн өгөх**



### **Дөрөв. Хамтын ажиллагааны хороо**

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг багийн иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

### **Тав. Гэрээний хэрэгжилт**

5.1. Талууд гэрээг тухайн жилийн 1-р улиралд багтаан Сумын засаг даргатай байгуулж, гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2 Талууд гэрээний хэрэгжилтийг сум орон нутагтаа хагас бүтэн жилээр дүгнэж сумын ИТХ-аар баталгаажуулан, хагас жилийн хэрэгжилтийг 07 сарын 20-ны дотор, жилийн эцсийн хэрэгжилтийг дараа оны 02 сарын 15-ны дотор Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ.

5.3 Орон нутагтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээний хагас бүтэн жилийн хэрэгжилтийг хавсралтад заасны дагуу Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс 02 сарын 20-ны дотор дүгнэж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д танилцуулна.

### **Зургаа. Гэрээний хариуцлага**

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

### **Долоо. Маргаан шийдвэрлэх**

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

### **Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ... жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Нутгийн захиргааны байгууллагыг  
төлөөлж,

Төв аймгийн, Заамар  
сумын Засаг дарга



Б.Самбуу

Хаяг: Заамар сум 4-р баг

Утас: 96961896

Ашигт малтмалын байгууллагыг  
төлөөлж,

Улз гол ХХК-ны захирал



А.Бүрэнтогтх

Хаяг: УБ хот, БЗД, оюутаны хотхон УЛЗ гол  
цогцолборын байр

Утас: 99112948, 99092068